

**МОНГОЛ УЛСЫН 2025 ОНЫ ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛТЭЙ ХАМТ  
ӨРГӨН МЭДҮҮЛСЭН ХУУЛЬ, МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛЫН  
ТӨСЛҮҮДИЙГ ЭЦСИЙН ХЭЛЭЛЦҮҮЛЭГТ БЭЛТГЭСЭН ТУХАЙ  
ТӨСВИЙН БАЙНГЫН ХОРООНЫ ТАНИЛЦУУЛГА**

2024 оны 11 дүгээр  
сарын 05-ны өдөр

Улаанбаатар  
хот

**Илтгэгч нь: Улсын Их Хурлын гишүүн Ж.Баясгалан**

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2024 оны 08 дугаар сарын 30-ны өдөр Улсын Их Хуралд Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хууль, Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслүүдийн анхны хэлэлцүүлгийг Улсын Их Хурлын чуулганы 2024 оны 10 дугаар сарын 31-ний өдрийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж, эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүлсэн.

Төсвийн байнгын хороо 2024 оны 11 дүгээр сарын 05-ны өдрийн хуралдаанаараа дээрх хууль, тогтоолын төслүүдийн эцсийн хэлэлцүүлгийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлд заасны дагуу явууллаа.

Нэгдсэн хуралдаанаар хууль, тогтоолын төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулах үед хуралдаан даргалагчаас Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.1 дэх заалтыг баримтлан төслийн зарим зүйл, заалтыг гүйцээн боловсруулах чиглэл өгсний дагуу дараах саналыг гүйцээн боловсруулж, хууль, тогтоолын төслийн холбогдох зүйл, хэсэг, заалттай уялдууллаа.

Монгол Улсын Их Хурал бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалд туссан импортыг орлох, экспортыг дэмжих төслийн жагсаалт болон гаалийн албан татварын хөнгөлөлтөд хамаарах боловсруулах үйлдвэрийн салбарын жагсаалтыг батлахаар холбогдох хуулийн төсөлд, мөн “Засгийн газрын үнэт цаас гаргах эрх олгох тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөлд Монгол Улсын Засгийн газраас 2025 онд 4.0 их наяд хүртэл төгрөгтэй тэнцэх хэмжээний гадаад, дотоод үнэт цаас гаргах, “Засгийн газарт чиглэл өгөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөлд улсын төсвийн хөрөнгөөр өмнөх онуудад ажил нь эхэлсэн боловч төсөвт өртөг нэмэгдэж байгаа барилга байгууламжийн төсөвт магадлал хийн, аудитын дүгнэлт гаргуулах ажлыг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд зохион байгуулж, саналаа 2025 оны 1 дүгээр улиралд багтаан Улсын Их Хуралд танилцуулах үүргийг Монгол Улсын Засгийн газарт өгөхөөр тусгалаа.

Нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлгээр олонхын дэмжлэг авсан саналуудыг холбогдох хууль, тогтоолын төсөлд нэмж тусган агуулга, бодлого, зарчмыг алдагдуулахгүйгээр үг хэллэг, дэс дараалал, бүтцийн шинжтэй засварыг хийж эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн хууль, тогтоолын төслүүд болон Төсвийн байнгын хорооны танилцуулгыг Та бүхэнд хүргүүлсэн.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийн эцсийн хувилбарын төсөл, эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Төсвийн байнгын хорооны танилцуулгыг хэлэлцэн шийдвэрлэж өгнө үү.

Анхаарал тавьсанд баярлалаа.

**ТӨСВИЙН БАЙНГЫН  
ХОРООНЫ ДАРГА**



**Ц.ДАВААСҮРЭН**